



**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ТЭЭВРИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2017 оны 06 сарын 06 өдөр

Дугаар 7/47

Улаанбаатар хот

**Зуслангийн нийтийн тээврийн
үйлчилгээг зохион байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Автотээврийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4, 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2016 оны А/928 дугаар захирамжаар батлагдсан Нийслэлийн Тээврийн газрын “Дүрэм”-ийн 2.5.3, 3.1.19 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Зуслангийн чиглэлийн нийтийн зорчигч тээврийн үйлчилгээг 2017 оны 06 дугаар сарын 10-ны өдрөөс эхлүүлэхтэй холбоотойгоор ЗҮ:1 “Гүнт-Жигжид-Тэнгис кино театр” чиглэлийн замналыг нэгдүгээр, ЗҮ:2 “Гоодой-Тэнгис кино театр” чиглэлийн замналыг хоёрдугаар, ЗҮ:3 “Баянбулаг-Тэнгис кино театр” чиглэлийн замналыг гуравдугаар хавсралт ёсоор тус тус баталж мөрдүүлсүгэй.

2. Дээрх чиглэлүүдийн үйлчилгээнд ажиллах тээврийн хэрэгслийн цагийн хуваарийг боловсруулж 2017 оны 06 дугаар сарын 10-ны өдрөөс үйлчилгээг эхлүүлэхээр нэгдсэн даалгаварт тусгахыг Тээврийн төлөвлөлт, технологийн хэлтэс /Д.Галбадрах/, үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж байгууллагатай байгуулсан гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж, олон нийтэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлан таниулах ажлыг зохион байгуулахыг Захиргааны удирдлага, санхүүгийн хэлтэс /Ц.Мөнхбат/, тухайн чиглэлийн өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулж, шуурхай зохицуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Зорчигч тээврийн үйлчилгээний хэлтэс /Э.Баярт/, үйлчилгээг батлагдсан замналын дагуу явуулах, ажиллах цагийн хуваарийн мөрдөлтөд хяналт тавьж ажиллахыг Тээврийн хяналтын хэлтэс /Ц.Мягмар/-т тус тус даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Х.Булгаа/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ОТГОНБААТАР

